



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Нийгмийн даатгалын сангийн 2014 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/19/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гэрэл
Утас: 261740
Цахим хаяг:
gerelts@audit.gov.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2-т тус тус заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Улсын төсвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт оршино.

Нийгмийн даатгалын сангийн удирдлага санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352, 2013 оны 269, 2014 оны 5, 55 дугаар тушаалаар баталсан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Байгууллагын эрх зүйн орчин

Нийгмийн даатгалын салбар:

- Нийгмийн даатгалын тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
- Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай
- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай
- Төрийн албаны тухай
- Хөдөлмөрийн тухай
- Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай
- Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Төсвийн тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын тогтоолууд:

- “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээ болон цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 15 дугаар тогтоол

НДҮЗ-ийн тогтоолууд:

- “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2013 оны 26 дугаар тогтоол
- “ЭМД-ын тусламж, үйлчилгээний зардлын дээд хязгаар тогтоох тухай” 2014 оны 15 дугаар тогтоол
- “Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллуудын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 18 дугаар тогтоол
- “Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай” 2014 оны 20 дугаар тогтоол
- “Нэрийн дансны 2013 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 2014 оны 24 дүгээр тогтоол
- “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай” 2014 оны 30 дугаар тогтоол
- “Өндөр өртөг бүхий мэс заслын тусламж үйлчилгээний зардлын тухай 2014 оны 36 дугаар тогтоол
- “Нэрийн дансны 2014 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 2015 оны 1 дүгээр тогтоол
- “НДС-гийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс харилцах, хадгаламж хэлбэрээр арилжааны банкинд байршуулах, бонд худалдан авах хэмжээг батлах тухай” 2015 оны 2 дугаар тогтоол

Үйл ажиллагааг тодорхойлсон дүрэм, журам

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам

Тус газрын мэргэжилтнүүд боловсруулж, НДЕГ-ын даргын 2009 оны 396 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн нэгтгэлийг тус газрын Мэдээллийн технологийн төвийн зохиосон “Үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн програм”-аар, НДС-гийн нэгтгэлийг Санхүүгийн тооцоолох компанийн Пластик програмаар гаргаж, 2015 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 1/660 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын ерөнхий газар

- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, санг бүрдүүлж орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,
- Иргэдийн нийгмийн хамгааллын талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, нийгмийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд зөв ойлгуулан сурталчилах,

- Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох,
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах,
- Эрдэм шинжилгээ, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар болон дангаараа нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах, таниулах, иргэдийг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүн

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 15-ны хооронд УАГ-ын САГ-ын дарга С.Энхзаяа удирдаж, аудитын менежер С.Оюунгэрэл аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Ц.Гэрэл шинэчлэн батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн аудитор хуульд заасан шаардлагын дагуу “Сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу гаргаж, газрын даргын баталгаажуулалт хийлгэн, архивын нэгжид хадгалсан болно.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн урьдчилан боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн болно.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, түүвэрчлэн шалгах аудитын горимыг хэрэгжүүлж, аудитын явцад нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзсэн нь санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах үндэслэл болсон.

Төлөвлөлтийн шатанд Нийгмийн даатгалын сангийн материаллаг байдлын түвшинг тайлант оны мөнгөн гүйлгээний тайлангаарх нийт зарлагын 2 хувиар тооцож 26,204.7 сая төгрөгөөр тогтоолоо. Даатгуулагч, ажил олгогчдоос төлөх шимтгэлийн орлогоос гадна төсвийн санхүүжилттэй сан тул мөнгөн зардлыг материаллаг байдлын суурь болгон авлаа.

Объект дээрх ажлын үе шатанд төлөвлөлтийн үеийн төсөөллөөс онцын зөрүүтэй асуудал гараагүй тул материаллаг байдлын түвшинг шинэчлэн тогтоогоогүй болно.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу олж тогтоосон эрсдэлтэй асуудалд нарийвчилсан сорилыг явуулж, үр дүнг ТАБ-СТА-В-3 маягыг ашиглан холбогдох дансдаар баримтжууллаа.

Мөнгөн хөрөнгийн дансны нийт олонлогоос санамсаргүй түүврийн аргаар сонголт хийсэн түүврийн сорилын үр дүнг ТАБ-СТА-В-5 маягтаар баримтжууллаа.

Олж тогтоосон эрсдэл, үр дагавар

Төлөвлөлтийн шатанд урьдчилсан таамаглалын дагуу дараах эрсдэл байж болох магадлалтай гэж үзсэн бөгөөд хэрэв эрсдэл байгаа тохиолдолд гарах үр дагаврыг тодорхойлсон болно.

Олж тогтоосон гол эрсдэл	Үр дагавар
• Санхүүгийн тайланд зарим үзүүлэлт зөрүүтэй тусгагдсан байх • Санхүүгийн тайлангийн нэгтгэлийг батлагдсан програмаар хийгээгүй байх	• Санхүүгийн үзүүлэлт буруу илэрхийлэгдэх • Нэгтгэсэн тайлан буруу гарах, улмаар ЗГСНТ-д нөлөөлөх

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын салбарын зарим байгууллагын 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд тус газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс санхүүгийн хяналт хийсэн байна.

Тухайлбал, Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг, Өмнөговь, Завхан, Увс, Ховд, Баянхонгор, Хэнтий, Булган, Сэлэнгэ аймгийн нийт 15 нийгмийн даатгалын хэлтэс, 150 сумыг хамруулан хяналт, шалгалт, үнэлгээ хийж, нийт 2.1 тэрбум төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, 1.8 тэрбум төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан нь 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу батлагдсан заавар, маягтын дагуу мэдээлэлүүдийг цаг тухайд нь байршуулан ажиллаж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын 2015 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан төсвийн хуваарь, эхний 3 сарын төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлт
- 5.0 сая төгрөгөөс дээш дүнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ нийт 1209,
- Төв орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд автомашин худалдан авах тухай нээлттэй тендер зарласан тухай мэдээлэл,
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч буй эрх бүхий этгээдийн жагсаалт: Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 325.7 мянган даатгуулагчид 350.7 тэрбум, тэтгэмжид 46.1 мянган даатгуулагчдад 25.5 тэрбум, төлбөрт 984.6 даатгуулагчдад 42.8 тэрбум төгрөг олгосон тухай мэдээллийг тус тус байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 1249.6 тэрбум төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс, 1141.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 91.4 хувиар биелүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сан	2013 он	2014 оны төлөвлөгөө	2014 оны гүйцэтгэл	/тэрбум төгрөгөөр/	
				өөрчлөлт	Хувь
Тэтгэврийн	635,0	785.2	705.3	-79.9	89.8
Тэтгэмжийн	67,3	87.2	78.4	-8.8	89.9
ҮОМШӨ-ний	86,7	90.3	99.8	9.5	89.5
Ажилгүйдлийн	25,7	26.4	26.3	-0.1	99.6
Эрүүл мэндийн	204,1	260.6	231.8	-28.8	88.9
НИЙТ	1018,8	1,249.6	1,141.6	-108.0	91.4

2014 онд орлогын төлөвлөгөө 108.0 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар тасарсан байна. Үүнд Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн орлогыг 1078.4 тэрбум төгрөгөөр төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн боловч 1249.6 тэрбум төгрөг болгож нэмсэн, шимтгэлийн авлага 17.7 тэрбум төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Зарлагын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг сангийн төрлөөр харуулбал:

Нийгмийн даатгалын сан	2013 он	2014 оны төлөвлөгөө	2014 оны гүйцэтгэл	/тэрбум төгрөгөөр/	
				өөрчлөлт	Хувь
Тэтгэврийн	826.4	993.7	1002.3	8.6	100.9
Тэтгэмжийн	58.7	73.3	78.5	5.2	107.1
ҮОМШӨ-ний	31.4	34.6	32.2	-2.4	93.1
Ажилгүйдлийн	16.1	18.4	19.1	0.7	103.8
Эрүүл мэндийн	125.5	190.3	182.9	-7.4	96.1
Нийт	1058.1	1310.3	1315.0	-4.7	100.4

2014 онд Нийгмийн даатгалын төсвийн зарлага нийт 4.7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангийн зардал 8.6 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хуулийн дагуу 570 орчим мянган хүн нөхөн тооцуулж, халамжийн тэтгэвэр авч байсан 12.7 мянган хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болсон, Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээг 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн,
- Тэтгэмжийн даатгалын сангийн зардал 5.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь төрөх насны эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 79.2-82.8 мянга болж жирэмсний болон амаржсаны тэтгэмж өссөн,
- Ажилгүйдлийн даатгалын сангийн зардал хэтэрсэн нь 2014 онд уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа зогсоож, орон тооны цомхотгол хийснээр ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагчдын тоо өссөн зэрэг шалтгаан нөлөөлсөн байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Нийгмийн даатгалын сан дотроо төв сан, орон нутгийн сангаас бүрдэх бөгөөд орон нутгийн сангуудын орлого төвлөрүүлэлт, зарцуулалтын дүнг харгалзан төв санд татан төвлөрүүлж, санхүүжилт дутагдсан орон нутагт олгох замаар сангийн зохицуулалтыг хийж байна.

2014 онд орон нутгийн сангуудаас нийт 445.8 тэрбум төгрөгийн орлогыг төв санд татан төвлөрүүлж, 349.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг орон нутагт олгосон байна.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг сар бүрийн 1-ний өдөр олгох ёстой бөгөөд энэ үед Нийгмийн даатгалын төв сангаас тухайн орон нутагт санхүүжилт олгоогүй байх тохиолдол байдаг. Энэ үед арилжааны банкуудтай байгуулсан гэрээний 3.7-3.8-д заасны дагуу ажлын 10 хоногийн хугацаанд түр санхүүжилт буюу хүүгүй зээл олгодог. 2014 онд арилжааны банкуудаас авсан 498.6 тэрбум төгрөгийн түр санхүүжилтийн, хүүгүй зээлийн тооцоо дараах байдалтай байна.

<i>№</i>	<i>Банк (тэрбум төгрөг)</i>	<i>Дүн</i>
1	ХААН банк	211.4
2	Төрийн банк	206.4
3	Капитал	75.2
4	Капитрон	1.6
5	Улаанбаатар хотын банк	2.8
6	ХАС банк	1.3
	<i>Дүн</i>	<i>498.6</i>

Аудитаар илрүүлсэн зүйлс болон тэдгээрийг шийдвэрлэсэн тухай

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах асуудал илэрснийг НДЕГ-ын удирдлагатай хэлэлцэж доорх байдлаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 7,629.4 сая төгрөгийн “Дуусаагүй барилга” бүртгэгдсэн байна.

Үүний дотор Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нийгмийн даатгалын хэлтсийн конторын барилга барих шийдвэр гарч барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2009 онд Корунд ХХК-тай гэрээ байгуулж, 2009-2013 онд нийт 631.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Уг барилга анхнаасаа техникийн нөхцөл аваагүйн улмаас барилгын ажил дууссан ч ашиглалтад ороогүй, улсын комисс хүлээж аваагүй байна. Улмаар НДҮЗ-ийн 2015 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор гүйцэтгэгч компанид борлуулж Нийгмийн даатгалын санг хохиролгүй болгох шийдвэр гараад байна.

Техникийн нөхцөл аваагүй барилгын ажил эхэлсэн нь Барилгын тухай хуулийн¹ холбогдох заалтыг зөрчсөн, барилга ашиглалтад ороогүйн улмаас тус дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс 2014 онд түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж 156.0 сая төгрөгийн түрээсийн зардал гаргасан байна.

Дүүргийн 5 дугаар хорооны нутагт баригдсан дээр дурдсан барилга ашиглах боломжгүй болсноос 13 дугаар хорооны нутагт байрлах хуучин цэцэрлэгийн барилгыг буулгаж, 1,349.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга шинээр барихаар 2014 оны төсөвт тусгасан байна. Улмаар Бүрэн дулаан ХХК-ийг сонгон шалгаруулж, Төрийн банкнаас гаргасан баталгааг үндэслэн 517.4 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна.

2014 оны төсөвт хуучин барилгыг буулгах зардал тусгагдаагүй тул 2015 оны Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар 76.2 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Орчид ХХК-тай гэрээ байгуулж, 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр гэрээ дүгнэх акт гарч, 2015 оны 4 дүгээр сарын 20-ны байдлаар шинэ барилгын газар шорооны ажил эхлээд байна.

- Хөрөнгө оруулалтын зардлыг Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Зураг төсөлгүй барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно”, 13 дугаар зүйлийн 13.2-т “...улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих...барилга, байгууламжийн зураг, төсөл, ...техник эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ”, 13.5-д “энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиодолд барилгын ажил эхлэхийг хориглоно” гэсэн, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх нь зүйтэй гэж үзэв.

2.2012 онд “Эко констракшн” ХХК-иас нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд тооцож авсан 77м² талбайтай 58.5 сая төгрөгийн үнэ бүхий хагас зоорийн давхрын объектыг 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр иргэн Ш.Баярсүх-д гэрээгээр худалдан борлуулж, 2014 онд “Бэлэн бүтээгдэхүүн” данснаас хасч авлагын дансанд тусгажээ. Гэрээний хавсралтаар баталсан төлбөрийн хуваарь ёсоор 2014 онд 31.7 сая төгрөгийн төлбөрийг хийхээр заасан боловч 21.0 сая төгрөг төлж, 10.7 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

- Хугацаандаа төлөөгүй төлбөрийн дүнгээр хоног тутам 0.05 хувийн алданги ногдуулахаар гэрээний 2.3-т заасны дагуу тооцож алданги ногдуулан, 2015 оны 4 дүгээр сарыг дуустал хугацааны төлбөрийг аудитын хугацаанд төлүүлэх албан шаардлага хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.

¹ □□□□□□□□ □□□□ □□□□ 2008 □□□ □□□□□□□□□□.

- Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахдаа мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тухайн өр үүссэн цаг хугацааны үнэ цэнтэй уялдуулж Нийгмийн даатгалын санг алдагдалгүй байхаар тооцоолж, борлуулах доод үнийг тогтоох журамд шилжих талаар зөвлөмж өгөх нь зүйтэй гэж үзэв.

3. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2014 онд 811.1 тэрбум төгрөг байгаагийн дотор арилжааны банкинд байршуулсан хадгаламж 532.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөн хөрөнгийн 65.5 хувийг эзэлж байна.

2013 онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 820.0 тэрбум төгрөгөөс 245.0 тэрбум төгрөгийн хадгаламж байршуулсан нь 29.8 хувийг эзэлж байсан бол тайлант онд хадгаламж 532.0 тэрбумд хүрч 287.0 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин өссөн байна.

2013 онд хадгаламжийн хүүгээс 25.4 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2014 онд 44.4 тэрбум төгрөгт хүрч 19.0 тэрбум төгрөгөөр буюу 74.8 хувиар өссөн байна. Хүүгийн төвшин 2014 онд 10.5-11.8 хувь байгаа бөгөөд НДҮЗ-ийн 2013 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-д өөрчлөлт оруулах тухай НДҮЗ-ийн 2014 оны 29 дүгээр тогтоолоор хүүгийн хэмжээг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тогтоохоор заасан байна.

Гэвч арилжааны банкинд хадгаламж байршуулж байгаа нь мөнгөн хөрөнгийн дүнг өсгөх менежмент боловч зөвхөн тухайн арилжааны банкнаас ирүүлсэн хүсэлт, НДҮЗ-өөс гаргаж буй шийдвэрийн дагуу гэрээ хийж байна.

Хадгаламж байршуулалтын асуудлаар Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас хийсэн шалгалт, улсын байцаагчийн дүгнэлтээр Өрсөлдөөн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож, банкуудын дунд шударга өрсөлдөөн бий болгож, сангийн чөлөөт үлдэгдлийг өсгөх боломжийг ашиглах талаар зөвлөмж өгсөн байна.

2013 онд нийт 894.5 тэрбум төгрөгийн шимтгэл тооцоолж, 889.6 тэрбум төгрөг буюу 99.4 хувийг төвлөрүүлж байсан бол тайлант 2014 онд 1,025.9 тэрбум төгрөгийн шимтгэл тооцоолж, 1,008.5 тэрбум төгрөг буюу 98.3 хувийг төвлөрүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос 118.9 тэрбум төгрөгөөр илүү байгаа боловч шимтгэл ногдуулалтаар тооцсон төвлөрүүлэлтийн хувийн жин 1.1 функээр буурсан үзүүлэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2013 оны эцсийн үлдэгдэл 8.8 их наяд, үүний дотор даатгуулагчдын хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах зорилгоор хийсвэрээр олгож буй хүү НДҮЗ-ийн 2014 оны 24 дүгээр тогтоолд заасан 22.3 хувиар тооцсоноор эхний үлдэгдэлд 1,502.0 тэрбум, шимтгэлд 111.5 тэрбум төгрөг нийт 1,613.5 тэрбум төгрөг байна.

“Нэрийн дансны 2014 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” НДҮЗ-ийн 2015 оны 1 дүгээр тогтоолоор “2014 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээ 18.6 хувь” гэж заасан бөгөөд эцсийн тооцоо хараахан гараагүй байна.

- Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын санг арилжааны банкинд байршуулахдаа Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шалгалтын тайлан, улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу банкуудын дунд чөлөөт өрөлдөөнийг бий болгох асуудлаар журамд нэмэлт өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Материаллаг бус залруулагдаагүй алдааны талаарх тайлбар

Материаллаг бус залруулаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал хандуулах бусад асуудал

А.Тэтгэврийн даатгалын нэрийн данс

Хуучин системийн үед нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангийн нийт дүнгээс төсөвт байгууллага 4.0 хувиар, үйлдвэр, аж ахуйн газар 13.5 хувиар тооцон Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад төлж ирсэн боловч дээрх хуримтлалыг шинээр байгуулагдсан нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлээгүй.

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай хууль хэрэгжиж эхлэхэд нэрийн дансны эхний үлдэгдлийг хийсвэрээр тооцож баталгаажуулсан, үе үеийн Засгийн газраас тэтгэврийг тодорхой хувиар нэмж ирсэн, бага хэмжээний тэтгэвэр тогтоогдох тохиолдолд тэтгэврийн доод хэмжээнд хүртэл өсгөдөг боловч Улсын төсвөөс зөвхөн 1995 оноос өмнөх тэтгэвэр тогтоолгогч, цэргийн тэтгэвэр авагчийн нэмэгдлийг олгодог, хүн амын дундаж наслалт өсч өндөр насны тэтгэвэр авах хугацаа уртассан зэрэг шалтгааны улмаас нийгмийн даатгалын сангийн алдагдал өсөх хандлагатай байна.

Б.Нийгмийн даатгалын сангийн авлага

НДС-гийн нэгтгэсэн балансад 1996-1999 онд дампуурсан арилжааны 6 банктай холбоотой 5.4 тэрбум төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Төлбөртэй үйлчилгээний авлага” хэлбэрээр тусгагдсан 42,220.8 сая төгрөгийн дотор НДШ-ийн авлага 41,813.0 сая төгрөг байна. Энэ нь 2014 онд үүссэн 24,856.3 сая, 2013 онд үүссэн 8,950.5 сая, 2012 он болон түүнээс өмнө үүссэн 8,006.1 сая төгрөгийн авлага байна. Энэхүү 3-аас дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах шаардлага тулгарч байна.

НДЕГ-ын даргын 2015 оны А/28 дугаар тушаалаар ажил олгогчийг дэмжих “Итгэлийн аян”-ыг 55 хоногийн хугацаанд зохион байгуулж, нийт 4.9 тэрбум төгрөгийн авлага барагдуулсан байна. Гэвч уг барагдуулалтыг насжилтаар нь гаргаж ирүүлээгүй байна.

В.Нийгмийн даатгалын сангийн програм хангамж

Тус газрын Мэдээллийн технологийн төвийн зохиосон програмаар санхүүгийн тайлан, түүний нэгтгэлийг гаргаж байгаа нь Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл аваагүй, авлага өглөгийн тооцооны туслах харилцагч тус бүрээр гардаггүй, хүн бүрээр цалингийн өссөн дүн гарч байгаа боловч бүрэлдэхүүн нь задаргаагаар харагддаггүй, үндсэн хөрөнгийн талаарх үзүүлэлтүүд дутуу харагддаг зэрэг дутагдалтай талууд байгаа нь нягтлан бодох бүртгэлийн ажилд хүндрэл учруулж байгааг анхаарч цаашид сайжруулах шаардлагатай байна.

Мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд цаг хугацаа ихээхэн зарцуулж байгаагийн нэг жишээ нь, аудитын явцад арилжааны банкуудаас 2014 онд авсан хүүгүй зээлийн мэдээллийг авах шаардлага гарахад тухайн банкнаас авах нь цаг хугацааны хувьд боломжтой байлаа.

Дараа жилүүдийн аудитаар авч үзэх асуудлууд

2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан баталгаажуулах үед энэ аудитаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг авч үзнэ.

“Эрүүл мэндийн даатгалын тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Нийгмийн даатгалын байгууллагаас Эрүүл мэндийн даатгалын албыг салгаж, тусгай агентлаг байгуулагдах үед үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, Эрүүл мэндийн даатгалын сангийн үлдэгдлийг зөв тооцож, шийдвэрлэсэн, шилжүүлсэн эсэхийг шалгах болно.

2015 оны нэрийн дансыг мөнгөжүүлэх шийдвэрийн биелэлтийг авч үзэх болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийгмийн даатгалын салбарын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар салбар нэгжүүдэд 52.2 сая төгрөгийн 26 зөрчилд зөвлөмж өгч, 325.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн багцад ҮАГ-аас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2014 оны 1/1766 дугаарт албан бичгээр ирүүлснээс үзвэл “Санхүү хариуцсан дотоод аудитор ажиллуулах” гэсэн зөвлөмжөөс бусад зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай тайлагнажээ.

Зөвлөмж

Аудитаар мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулахдаа Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шалгалтын тайлан, улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу чөлөөт өрсөлдөөний замаар сонгон шалгаруулалт явуулах тогтолцоонд шилжих, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд тусгахдаа Барилгын тухай болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөх, шимтгэлийн өрөнд авсан үл хөдлөх хөрөнгийн борлуулахдаа тухайн үеийн мөнгөний үнэ цэнийг тооцоолж Нийгмийн даатгалын санг хохиролгүй болгоход чиглэсэн бодлого баримтлах талаар нийт 3 зөвлөмж өглөө.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Бид Нийгмийн даатгалын сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө-Хадгаламж

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2: Шимтгэлийн өрөнд авсан барааны борлуулалт

Асуудал 3: Хөрөнгө оруулалт

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг НДС-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь НДЕГ-ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан НДЕГ-ын дарга Ц.Уртнасан, Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Ч.Чулуунчимэг, ахлах нягтлан бодогч Б.Наранмандах болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

2014 онд Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 811.1 тэрбум төгрөг байгаагийн дотор арилжааны банкинд байршуулсан хадгаламж 532.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөн хөрөнгийн 65.5 хувийг эзэлж байна.

2013 онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 820.0 тэрбум төгрөгөөс 245.0 тэрбум төгрөг хадгаламж байршуулсан нь 29.8 хувийг эзэлж байсан бол тайлант онд хадгаламж 532.0 тэрбумд хүрч 287.0 тэрбум төгрөгөөр буюу 2.1 дахин өссөн байна. 2013 онд хадгаламжийн хүүгээс 25.4 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2014 онд 44.4 тэрбум төгрөгт хүрч 19.0 тэрбум төгрөгөөр буюу 74.8 хувиар өссөн байна. Гэвч арилжааны банкинд хадгаламж байршуулж байгаа нь мөнгөн хөрөнгийн дүнг өсгөх менежмент боловч зөвхөн тухайн арилжааны банкнаас ирүүлсэн хүсэлт, НДҮЗ-өөс гаргаж буй шийдвэрийн дагуу гэрээ хийж байна.

Өрсөлдөөний үндсэн дээр байршуулбал илүү өсгөх боломж байх магадлалтай тул Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу банкуудын дунд өрсөлдөөн бий болгох шаардлагатай байна.

Эрсдэлүүд

Арилжааны банкуудыг өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулаагүйгээс мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг өсгөх боломжийг алдах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын санг арилжааны банкинд байршуулахдаа Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу банкуудын дунд чөлөөт өрөлдөөнийг бий болгох замаар сонгон шалгаруулдаг тогтолцоонд шилжих;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшилцсөн.

ҮАГ-ын ажиглалт

2012 онд “Эко констракшн” ХХК-иас нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд тооцож авсан 77м² талбайтай 58.5 сая төгрөгийн үнэ бүхий хагас зоорийн давхрын объектыг 2013 оны 12 дугаар сарын 19 ний өдөр иргэн Ш.Баярсүхэд гэрээгээр худалдан борлуулж, 2014 онд “Бэлэн бүтээгдэхүүн” данснаас хасч авлагын дансанд тусгажээ. Гэрээний хавсралтаар баталсан төлбөрийн хуваарь ёсоор 2014 онд 31.7 сая төгрөгийн төлбөрийг хийхээр заасан боловч 21.0 сая төгрөг төлж, 10.7 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахдаа мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тухайн өр үүссэн цаг хугацааны үнэ цэнтэй уялдуулж Нийгмийн даатгалын санг алдагдалгүй байхаар тооцоолж борлуулах доод үнийг тогтоох журамд шилжих арга хэмжээ авах;

Эрсдэлүүд

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өсгөх боломж алдах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшилцсөн.

ҮАГ-ын ажиглалт

НДС-гийн хөрөнгөөр 2009 оноос баригдаж эхэлсэн Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн барилга 2009 онд ашиглалтад орохоор төлөвлөсөн, нийт 631.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Барилгын ажил дууссан боловч бүх техникийн нөхцөл аваагүйн улмаас улсын комисс хүлээж аваагүй, улмаар гүйцэтгэгч компанид борлуулах шийдвэр 2015 онд НДҮЗ-өөс гарсан байна.

Техникийн нөхцөл аваагүй барилгын ажил эхэлсэн нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Зураг төсөлгүй барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно”, 13 дугаар зүйлийн 13.2-т “...улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих...барилга, байгууламжийн зураг, төсөл, ...техник эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ”, 13.5-д “энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиодолд барилгын ажил эхлэхийг хориглоно”

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана. гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

НДС-гийн мөнгөн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Хөрөнгө оруулалтын зардлыг Барилгын тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшилцсөн.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.24 № 811

танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХАХНХ-ЫН САЙД С.ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

